



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 37 дугаар зарлигийн хавсралт

ЦЭРГИЙН ДЭЭД ЦОЛ ОЛГОХ ЁСЛОЛЫН ЖУРАМ

Нэг.Ерөнхий заалт

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар хүртээсэн цэргийн дээд цолыг олгохдоо энэ журмыг баримтална.
2. Цэргийн дээд цол олгох ёслолыг Төрийн ордны “Соёмбо” танхимд гүйцэтгэнэ.
3. Цэргийн дээд цолны батламж бичиг, мөрдэсийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч гардуулна.
4. Цэргийн дээд цол олгох ёслолд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Ерөнхийлөгчийн цэргийн бодлогын зөвлөх, цэргийн дээд цол хүртэгчийн шадар захирагч /дарга/ байлцана.

Хоёр. Ёслол үйлдэх журам

- 5.Цэргийн дээд цол хүртэж буй офицер цэргийн ёслолын дүрэмт хувцастай цол олгох ёслол үйлдэх танхимд хүрэлцэн ирнэ.
- 6.Цэргийн дээд цол хүртээх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын эрх бүхий албан тушаалтан уншина.
- 7 Зарлиг уншсаны дараа Монгол Улсын Ерөнхийлөгч генерал цол хүртээсэн батламж бичгийг, генерал цолны мөрдэсийн хамт цэргийн дээд цол хүртэгчид гардуулж, баяр хүргэнэ.

8.Цэргийн дээд цол хүртэгч Монгол Улсын Ерөнхийлөгчид цэргийн дүрэмд заасны дагуу талархал илэрхийлнэ.

9.Цэргийн дэд цол хүртэгч генералын ёслолын дүрэмт хувцсаа өмсч, цэргийн дээд цол хүртсэн тухайгаа Ерөнхийлөгчид илтгэнэ.

-----oOo-----